

## САНАЛ АСУУЛГА

1.Хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

4.Аймаг, сумдын Засаг дарга нараас иргэдэд үзүүлж буй үйлчилгээ

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Хангалттай
- Г. Дутагдалтай
- Д. Хангалтгүй

Төрөөс нэн түрүүнд ямар үйлчилгээ авахыг хүсч байна вэ?

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭГ ТООЦСОН ДҮН**

**2010.03.25**

**Улиастай**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2009 оны 7 дугаар сард бүх сумдын төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн ажлын хэсгүүдийн удирдамжид тусган, Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан журмын 5.5 дахь заалтыг хэрэгжүүлж, /Энэ тогтоол хүчинтэй мөрдөгдөж байсан болно./ Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний үнэлгээ гэсэн үзүүлэлтээр сумдын насанд хүрсэн иргэдийн 5 хүртэл хувийг хамруулж, санал асуулга явуулсан. Үүний дүнг үндэслэн хэрэглэгчийн үнэлгээг гаргаж байна. Санал асуулгад нийт 3116 хүн оролцож, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 4.56, Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмж 4.81, нийт үнэлгээ 4.68 буюу 93,6 хувийн дүнтэй байна. Сумдын өвөлжилтийн байдалтай танилцах, гадны аймагт болон өөрийн аймгийн сумдад отор хийж яваа малчдыг эргэх ажлыг 2-3 удаа зохион байгуулж, 580 гаруй өрхөд аймгаас хүн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, санал хүсэлтийг сонсож, төлөвлөгөө гарган, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд хариуцуулж үүрэг даалгавар өгч хэрэгжүүлж байна. Мөн Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарын үеэр авсан төрөл бүрийн судалгааны дүн санал дүгнэлтийг төрийн байгууллагуудын бодлого чиглэлд тусгаж байна.

Төрөөс нэн түрүүнд ямар үйлчилгээ авахыг хүсч байна вэ гэсэн асуултад иргэд доорхи хүсэлтүүдийг тавьж байна.

- Хөнгөлөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх
- Хөдөө, орон нутгийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, тэдний нийгмийн баталгааг сайжруулах
- Оюутан, сурагчдын сургалтын төлбөрийг төрөөс хариуцан төлөх, хөнгөлөлт үзүүлэх

-Орон нутагт өвөлжилт хүндэрч, зуд болсноос олон өрх малгүй болж, ажилгүйдэл ядуурал ихсэж байгаа тул цаашид малжуулах бодлого баримтлах

-Малчдын гар дээр тэжээлийн нөөцгүй болж, өвөл тэжээж байсан мал ид үхэж байна. Төлийн зөөлөн өвс, сүү орлох тэжээл шаардлагатай байна.

-Сумдад төрийн мал эмнэлгийн үйлчилгээг бий болгох

-Малчдыг банкны зээлийн өрийн дарамтаас чөлөөлөх, хүүг хөнгөлөх талаар дэмжлэг үзүүлэх

-Байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн тодорхой бодлого хэрэгтэй байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР